

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАНГИЙН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2024/18-10-ШТА-ГА/

Дундговь дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Б.Гантуяа Утас: 7059-2208,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

“УЛС ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2024.05.16

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ДУА-2024/18-10-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Аймгийн ЗД, АЗДТГ-ын ХОХБТХ, ГХБХБГ.
Аудитын нэр:	“Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Аудитын 3-р нэгж Ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамрах хүрээ:

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- ✓ Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Аудитыг Дундговь аймагт 2023 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнгийн хүрээнд үндэслэн хийсэн. Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу

аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

2. Аудитын дүн: Бүлэг 1.

А. Хариулт 1: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 88.9 хувийг холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн байна.

А.1. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Дундговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 138,382.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл арга хэмжээнээс тайланд онд 36,194.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Дээрх 2023 онд хэрэгжих нийт төсөл арга хэмжээний 116,040.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл арга хэмжээ эрх шилжээгүй, 22,341.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээ эрх шилжиж ирсэн байна. Тайлант онд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Төсөл арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоо болон төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргаагүй байна. Тухайлбал: Говь-Угтаал сумын Спорт залны барилга, Хулд сумын Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад орсны дараа үйл ажиллагаа, ашиглалтын болон бусад зардлын эх үүсвэрийг тодорхойлоогүй байна.

Иймд УТХО-оор хийгдэх төсөл арга хэмжээг эрэмбэлэхдээ нийгэм, эдийн засгийн үр ашиг, шинээр ашиглалтад орж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцож, холбогдох журмын шалгуурыг хангасан ТАХ-г хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

А.2. Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж байгаа эрх шилжсэн 9 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг анх 17,352.1 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна. 2023 оны Төсвийн тухай хуулиар 22,341.6 сая төгрөг буюу 4,989.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь "Төв халх" дуулалт жүжгийн театрын барилгын ажлын төсөвт өртгийг 3,743.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 4 төсөл, арга хэмжээний 1,245.8 сая төгрөгийн үний өсөлтийг тооцсонтой холбоотой байна. Эдгээр төсөл, арга хэмжээний үний өсөлтийг Барилгын хөгжлийн төвийн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулж Үндэсний аудитын газар хянасан байна.

А.3. Тус аймагт шилжиж ирсэн 22,341.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээг 2023 онд 5,928.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 4,860.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан хугацаанд санхүүжүүлсэн байна. Төв халх" дуулалт жүжгийн театрын барилгын 2023 онд төлөвлөгдсөн 671.7 сая төгрөг, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилга 240 суудал барилгын ажил хийгдээгүй улмаас 164.7 сая төгрөг, Эрдэнэдалай сумын төвийн хатуу хучилттай 2 км авто замын ажлын үнийн өсөлтийн зөрүүг бодит гүйцэтгэл 72.8 хувьд үндэслэн санхүүжүүлсэн 90.9 сая төгрөг нийт 255.6 сая төгрөгийг буцаан татуулсан байна. Мөн Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламжийн 99.9 сая төгрөгийн санхүүжилтийг 2024 онд олгохоор тооцсон байна.

Б. Хариулт 2: Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байна.

Б.1. Тайланд хугацаанд бүрэн хэрэгжиж дууссан 3 төсөл арга хэмжээ байна. Үүнээс "Шинэ хөдөө" төслийн тоног, төхөөрөмжийг аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/181 тоот захирамжаар, Сайнцагаан сумын 150 ортой 2 дугаар Цэцэрлэгийн барилгыг 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 41/2023 дугаар бүхий барилга, байгууламж ашиглалтад авах дүгнэлтээр, хүлээн авах комиссыг мэргэжлийн болон ашиглагч байгууллагын бүрэлдэхүүнтэй байгуулан, комиссын саналыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулж, дүгнэлт гарган хүлээн авсан байна.



Өмнөх аудитаас өгсөн уг барилга, байгууламжийн ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа дуусаагүй тул Барилгын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.6-т /Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна/ заасны дагуу гүйцэтгэгчийн зардлаар засвар хийлгэж, хүлээн авах талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажил”-ын анх батлагдсан гэрээний дүнг 334.1 сая төгрөгийн үний өсөлтөөр нэмэгдүүлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 79 хувьтай байна. Гүйцэтгэгч “Өлзийхутагийн наран” ХХК-ний тодорхойгүй шалтгааны улмаас ажил зогссон байна. ЗТХЯ-аас ажлын хэсэг гарч тухай ажилд хяналт шинжилгээ хийсэн бөгөөд ямар дүгнэлт гарсан талаар мэдээлэл байхгүй байна. “Говь-Угтаал сумын Спорт залны барилга”, “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажил”-ууд 2019 онд эхэлсэн бөгөөд одоог хүртэл дуусаагүй байгаа нь гэрээг хангалтгүй биелүүлсэн байна. Цаашид дээрх ажлыг гэрээний хугацаанд дуусгах ажлыг холбогдох яамдуудтай хамтран шийдвэрлэх шаардлагатай байна.



Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын шугам сүлжээ болон гадна тохижилтын ажлыг төлөвлөөгүйгээс дотор заслын ажил хийгдэхгүй болж барилгын ажил удааширсан байна. Барилгын хөгжлийн төвийн 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 1291/2023 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр гадна шугам сүлжээний ажлын зураг, төслийн 775.2 сая төгрөгөөр баталгаажуулсан байна. Тус барилгын гадна шугам сүлжээний ажлын төсвийг 2024 оны Төсвийн тухай хуулиар 764.8 сая төгрөгөөр батлагдсан байна. Тус 240 суудалтай соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зарлаж 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нээсэн боловч оролцогч ороогүй байна. Гадна шугам сүлжээ, тохижилтын ажлыг 2024 онд 100.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан нь тус барилгын ажил удааширч, гэрээний хугацаандаа буюу 2024 оны 09 дүгээр сарын 30-д ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Иймд гадна шугам сүлжээ, тохижилтын ажлын төсвийн 764.8 сая төгрөгийг бүрэн батлуулж барилгын ажлыг дуусгах шаардлагатай байна.

Б.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга, байгууламжид Дундговь аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсээс тухай бүр захиалагчийн хяналтыг хийж, фото зургаар баримтжуулж, өгсөн үүрэг даалгаврынхаа хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.



Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал

Хүснэгт: №1

№	Төсөл, арга хэмжээний нэр	Захиалагчийн хяналт хийсэн тоо	Техник хяналтын зардал /сая төгрөгөөр/
1	Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж	1	2.6
2	Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж	5	9.5
3	Сайнцагаан сумын Цэцэрлэгийн барилга	2	42.5
5	Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилга	1	2.3
	Нийт дүн	9	56.9

Захиалагчийн хяналтыг тайланд онд давхардсан тоогоор 9 удаа хяналт хийж, техник хяналтын зардалд 56.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1¹ дахь заалтыг мөрдөж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Б.3. Тайланд онд хэрэгжиж дууссан Сайнцагаан сумын 150 ортой хүүхдийн Цэцэрлэгийн барилгыг гадна тохижилтын хамт 2,710.0 сая төгрөгөөр тус Цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн данс, Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг Баянжаргалан, Гурвансайхан, Эрдэнэдалай, Луус, Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэсэн байна. Харин Биеийн тамир, спортын газрын дансанд бүртгэлтэй Цэнгэлдэх хүрээлэнгийн “Наадмын талбайн дуусгал” ажлын 420.1 сая төгрөгийн 2023 оны 02 дугаар сарын 19-д олгосон үний зөрүүг Төрийн өмчийн хорооны шийдвэр гараагүй шалтгаанаар тус газрын үндсэн хөрөнгийн дансанд одоог хүртэл нэмж капиталжуулж бүртгээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

Энэ нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалаалтад тавих хяналт суларч, хөрөнгө үрэгдэх, шамшигдах үр дагавартай байна.

Иймд УТХО-оор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон, хөрөнгө оруулалтыг хүлээн авах комиссын шийдвэр гарсан даруй баримт материалыг бүрдүүлэн шийдвэр гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлэн эзэмшигч байгууллагын холбогдох дансанд бүртгэж хэвших зүйтэй байна.

В. Харцулт 3: Төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүд хугацаандаа хэрэгжихгүй үр дүн муутай байна.

В.1. Тайлант онд Дундговь аймгийн хэмжээнд эрх шилжиж ирсэн 9 төсөл, арга хэмжээнээс Сайнцагаан сумын 150 ортой 2 дугаар цэцэрлэг, орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн 2 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан байна. Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулснаар өмнөх хүчин чадлыг 50 хувиар нэмэгдүүлж, тойргийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг дээшлүүлж, сургалтын орчинг сайжруулсан үр дүнтэй хөрөнгө оруулалт болсон байна. Тус Цэцэрлэгт тойргийн 180 хүүхэд суралцаж байна. Мөн "Шинэ хөдөө" төсөлд хамрагдсан 5 сумын малчдын хөнгөвчлөх зорилгоор явуулын хонь хяргах, ангилах, савлах, шахаж пресслэх, хяргасан хонийг халдварт өвчнөөс сэргийлж угаах иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. Тус тоног төхөөрөмж нь 2023 оны 08 дугаар сард нийлүүлэгдсэн тул тайлант онд ашиглаагүй байна. Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглаж, ажиллуулах талаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний малжуулах төсөлд хамрагдсан залуу малчдыг хамруулан сургагч багшаар бэлтгэж, малчдын бүлэг байгуулан ажиллахаар төлөвлөж байна.

В.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдэх эрх шилжиж ирсэн 9 төсөл арга хэмжээ нь хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтойгоор төлөвлөсөн байна. Шилжих хөрөнгөөр хийгдэж барилга байгууламжийн 5 барилга байгууламжийг Сангийн сайдын 2018 оны 295-р тушаалаар баталсан журмын дагуу үнэлж, эрэмбэлсэн байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 28 төсөл арга хэмжээний саналыг Сангийн яам болон бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн боловч дээрх төсөл арга хэмжээний саналд үндэслэгдээгүй Хулд сумын Ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмж, Цагаандэлгэр сумын Соёлын төв, Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж зэрэг 3 төсөл арга

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна ”

хэмжээ батлагдаж ирсэн байна. Энэ нь эрх шилжиж ирсэн нийт төсөл арга хэмжээний төсвийн 33.3 хувийг эзэлж байна. Эрх шилжиж ирсэн 9 төсөл, арга хэмжээний 6 төсөл, арга хэмжээг 2023 онд гүйцэтгэж дуусгахаар гэрээ байгуулсан боловч 3 төсөл, арга хэмжээ нь хугацаандаа дуусаж бусад төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа 2024-2025 онд дуусахаар сунгагдсан байна.

Иймд гэрээнд заасан хугацаандаа хэрэгжихгүй байгаа төсөл, арга хэмжээнүүдийг сунгагдсан гэрээний хугацаанд нь бүрэн ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулж, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх хүртэл арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй нийцүүлэн төлөвлөсөн ч орон нутгаас хүргүүлсэн саналыг хасаж, тус аймагт эрэмбэлэгдээгүй төсөл арга хэмжээг баталсан байна. Тухайлбал: Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламжийн ажил байна.

Цаашид улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих барилга байгууламжийг орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг судлаж, иж бүрэн байхаар төлөвлөж гэрээнд заасан хугацаанд нь хүлээж авч, ашиглалтад оруулж, эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломж нөхцөлийг хангах шаардлагатай байна.

Энэ нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэлгүй, судалгаа хийгээгүй төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, төлөвлөсөн арга хэмжээ үр дүнгүй болох сөрөг үр дагавартай байна.

Иймд УТХО-оор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3²-т заасныг баримталж байх нь зүйтэй байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн зарим төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй, түүнээс ард иргэдийн хүртэх үр өгөөж, үр дүн багатай байна.

1. Төсөл арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоо болон төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт гаргаагүй байна.
2. Барилга, байгууламжийн хүлээн авах комиссыг мэргэжлийн болон ашиглагч байгууллагын бүрэлдэхүүнтэй байгуулан, комиссын саналыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулж, дүгнэлт гарган хүлээн авсан байна.
3. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.
4. “Наадмын талбайн дуусгал” ажлын үний зөрүүг Төрийн өмчийн хорооны шийдвэр гараагүй шалтгаанаар тус газрын үндсэн хөрөнгийн дансанд одоог хүртэл нэмж капиталжуулж бүртгээгүй байна.
5. Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулснаар өмнөх хүчин чадлыг 50 хувиар нэмэгдсэн нь, тойргийн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг дээшлүүлж, сургалтын орчинг сайжруулсан үр дүнтэй хөрөнгө оруулалт болсон байна.
6. “Говь-Угтаал сумын Спорт залны барилга”, Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын шугам сүлжээ болон гадна тохижилтын ажлыг иж бүрэн төлөвлөөгүйгээс дотор заслын ажил хийгдэхгүй болсон, “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажил”-ын

² 5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

барилгын ажил гүйцэтгэгч “Өлзийхутагийн наран” ХХК-ны хариуцлагагүй байдлаас шалтгаалан тус тус удааширч байна.

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээг эрэмбэлэхдээ нийгэм, эдийн засгийн үр ашиг, шинээр ашиглалтад орж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцож, холбогдох журмын шалгуурыг хангасан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах;
2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих барилга байгууламжийг орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг судлаж, зураг, төсөл, ТЭЗҮ-г боловсруулан иж бүрэн байхаар төлөвлөж, гэрээнд заасан хугацаанд нь хүлээж авч, ашиглалтад оруулж, ард иргэдэд үр өгөөжийг хүртэх боломж нөхцөлийг ханган ажиллах;
3. “Эрдэнэдалай сумын хатуу хучилттай авто замын ажил”-ын барилгын ажил гүйцэтгэгч “Өлзийхутагийн наран” ХХК-ныг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, ажлыг бүрэн дуусгуулах арга хэмжээ авч ажиллах;
4. “Говь-Угтаал сумын Спорт залны барилга”-ын шугам сүлжээ болон гадна тохижилтын ажлын зураг, төслийг Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороотой хамтран яаралтай хийлгүүлэн, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулан барилгын ажлыг дуусгуулах ажлыг зохион байгуулах;

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгч удирдлагын шийдвэр гаргалтад зөвлөн туслаж, төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд нь ашиглалтад оруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал:

ҮАГ-аар дамжуулан холбогдох яамдад удааширалтай байгаа барилга байгууламжийн ажлыг гэрээний хугацаанд дуусгах саналыг уламжилж байна.

Үндэслэл 1:

Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын шугам сүлжээ болон гадна тохижилтын ажлыг төлөвлөөгүйгээс дотор заслын ажил хийгдэхгүй болж барилгын ажил удааширсан байна. Тус 240 суудалтай соёлын төвийн барилгын гадна инженерийн шугам сүлжээ, гадна талбайн тохижилтын угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зарлаж 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нээсэн боловч оролцогч саналаа ирүүлээгүй байна. Гадна шугам сүлжээ, тохижилтын ажлыг 2024 онд 100.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан нь тус барилгын ажил удааширч, гэрээний хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

/Дэлгэрэнгүйг тайлангийн Б бүлгийн Б.1-р хэсгээс харна уу/

Санал 1:

Иймд Соёлын сайдын багцад Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын гадна шугам сүлжээ, тохижилтын ажлын энэ онд санхүүжих дүнг нийт өртөг болох 764.8 сая төгрөгийг бүрэн батлуулж барилгын ажлын явцыг түргэсгэх;

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН